



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/128

Мандалговь

Ашигт малтмал тээвэрлэлтийн
чиглэл батлах тухай

Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Салхитын мөнгөний уурхайгаас Говьсүмбэр аймаг хүртэлх 150 км ашигт малтмал тээвэрлэлтийн авто замын чиглэлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан чиглэлийн дагуух орон нутгийн чанартай авто замыг арчилж хамгаалан, замын тэмдэглэгээ байрлуулж, маршрутын дагуу тээвэрлэлт явуулж байхыг "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Т.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хүрээнд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Авто тээврийн төв (Ц.Бямбацогт), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010372

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
дугаар сарын 05-ны өдрийн 1128 дугаар
захирамжийн хавсралт

ГУРВАНСАЙХАН СУМЫН САЛХИТЫН МӨНГӨНИЙ УУРХАЙГААС
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ХҮРТЭЛХ 150 КМ АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛИЙН СОЛБИЦОЛ

№	Байршил	Уртраг	Өргөрөг
1.	Салхит уурхай	106 59 38.18	45 51 16.41
2.	Салхит уул	106 56 57.63	45 47 22
3.	Ажирхай	106 23 13.9	45 50 57.5
4.	Говь-Угтаал	107 31 25.77	46 01 45.56
5.		107 40 23.50	46 00 52.42
6.	Чойр	108 21 25.45	46 20 43.25